

Нийлүүлэгчдийн ёс зүйн дүрэм



Үүрэг амлалтаа биелүүлэх

Рио Тинто компанийн хүндлэл, ёс зүй, хамтын ажиллагаа, хариуцлага зэрэг үндсэн үнэт зүйлс нь хэрэглэгч, орон нутгийн ард иргэд, нийлүүлэгч нартайгаа зүй зохистойгоор бизнес эрхлэх үндэс суурь юм.

Бид ямар ч ажлыг хийхдээ салбартаа хамгийн өндөр стандарт, ёс зүйн хамгийн хатуу шаардлагуудыг тавьж ажилладаг. Ингэх нь зөв зүйтэй төдийгүй, итгэлцлийг бэхжүүлэх, үйл ажиллагаа явуулах зөвшөөрлөө хадгалан авч үлдэхэд зайлшгүй шаардлагатай юм.

Рио Тинто компани ашигт малтмалын хайгуул, олборлолт, боловсруулалтын үйл ажиллагаа явуулахдаа шинэлэг сэтгэлгээ, хариуцлагатай гүйцэтгэлд тулгуурлан үйл ажиллагаагаа илүү боловсронгуй болгохыг байнга эрмэлзэж байдаг. Бид дэлхийн олон оронд үйл ажиллагаа явуулж, хөнгөн цагаан (боксит, хөнгөн цагааны исэл), зэс, алмаз, нүүрс, уран, алт, аж үйлдвэрийн ашигт малтмал (борат, титаны давхар исэл, давс), төмрийн хүдэр олборлодог. Бидний нийлүүлдэг метал, ашигт малтмалын бүтээгдэхүүн орчин үеийн амьдралын хэв маяг, хүн төрөлхтөний хөгжил дэвшлийг тэтгэдэг.

Та манай нийлүүлэгч болохынхоо хувьд, бидэн хүлээсэн үүрэг амлалтаа биелүүлэхэд маань ихээхэн тус дэм болох билээ. Бид зөвхөн өөрсдөдөө зогсохгүй, бидний ажиллаж буй улс орон, засгийн газар, хэрэглэгчид, хөрөнгө оруулагчид, бусад оролцогч талууддаа итгэл хүлээлгэж, итгэлцэл дээр тулгуурласан үйл ажиллагаа явуулдаг. Бид бусадтай хамтран ажиллаж, харилцан итгэлцэж амжилтад хүрэх болно.

Нийлүүлэгчдийн ёс зүйн дүрэм нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартууд болон Рио Тинто компанийн Бидний ажлын арга барил дээр тулгуурласан бөгөөд танаас болон танай охин компани, давхар гэрээлэгчдээс шаардах бидний хүлээлтийг тусгасан. Бид энэхүү хүлээлтийг хангаж чадаагүй нийлүүлэгч нартай хамтын ажиллагаа эхлүүлэхгүй эсвэл цаашид үргэлжлүүлэхгүй байхаар шийдвэрлэж болно.

Хамтран ажиллаж байж л бид бүхэн бизнесээ зөв шударга арга замаар явуулж чадна.

Нийлүүлэгчдийн ёс зүйн дүрмийн талаар эсвэл нийлүүлэгч, бизнесийн хамтрагчдаасаа шаардах бидний хүлээлтийн талаар асууж тодруулах зүйл байвал suppliercodeofconduct@riotinto.com хаягаар хандана уу.

1. Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны гүйцэтгэл

Бид хүн бүр өдөр бүр ажлаа тараад гэртээ эсэн мэнд, эрүүл саруул харьдаг байхыг зорилтоо болгон ажилладаг. Бид энэхүү зорилтыг санал нэгтэйгээр хэрэгжүүлэх нийлүүлэгчидтэй хамтран ажилладаг. Үүнд:

- Ажилчид, туслан гүйцэтгэгч нарыг зохих шаардлага хангасан хувийн хамгаалах хэрэгсэл, эрүүл, аюулгүй ажиллах орчноор хангадаг.
- Ажлын байран дах нас баралт, гэмтэл, өвчлөлийг арилгах бүх боломжит арга хэмжээг авдаг.
- Ажилчдын нэр төр, хувийн орон зайг хамгаалсан, эрүүл, цэвэр, аюулгүй орон байраар хангадаг.

2.

Засаглал, хууль дүрмийн хэрэгжилт

Бид үйл ажиллагаа явуулахдаа ёс зүйн хэм хэмжээ, хууль ёсны дагуу өрсөлддөг. Бид дараах шаардлагуудыг хэрэгжүүлдэг нийлүүлэгчидтэй хамтран ажилладаг.

- Холбогдох бүх хууль тогтоомж, дүрэм журмыг дагаж мөрддөг.
- Ажилчид, туслан гүйцэтгэгчдийн хувийн үйл ажиллагаа, ашиг сонирхол нь Рио Тинто компанийн өмнө хүлээсэн үүрэг хариуцлагад нь харшилдаггүй.
- Ажил хөнгөвчлөх төлбөр зэрэг аливаа хэлбэрийн авилга, хээл хахуульд холбогддоггүй.
- Аливаа зөрчил, зохисгүй үйлдлийг мэдээлдэг, санал гомдлоо чөлөөтэй илэрхийлдэг, ингэснийхээ төлөө арга хэмжээ авахуулна гэсэн айдасгүйгээр ханддаг байлгах бодлого, үйл ажиллагаа хэрэгжүүлдэг.

3. Хөдөлмөрийн ба хүний эрх

Бид НҮБ-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг дэмждэг. Бид хүний дараах үндсэн эрхийг дээдэлдэг нийлүүлэгчидтэй хамтран ажилладаг.

- Албадан хөдөлмөр эрхлэлтгүй, бүх ажлаа чөлөөтэй сонгох боломжоор хангадаг.
- Бүх ажилчид хуулиар тогтоосон хөдөлмөр эрхлэх насанд хүрсэн, хууль бус хүүхдийн хөдөлмөр эрхлэлтээс урьдчилан сэргийлдэг.
- Бүх ажилчдыг шударга цалин хөлс, ажиллах нөхцөлөөр хангадаг.
- Шударга бус ялгаварлан гадуурхал, дарамтаас урьдчилан сэргийлж, хүнлэг харилцааг дэмждэг.
- Ажилчид хуулийн хүрээнд, тайван замаар эвлэлдэн нэгдэх, үйлдвэрчний эвлэлд элсэх, хамтын хэлэлцээр хийх эрхийг хүндэтгэн үздэг.
- Ажилчдын болон хэрэглэгчдийн хувийн нууцыг дээдэлж, хувь хүний мэдээллийг цуглуулах, ашиглах, хамгаалах үйл ажиллагаагаа хууль тогтоомжид нийцүүлсэн.

4. Байгаль орчны гүйцэтгэл

Бид үйл ажиллагаагаа явуулж байгаа бүс нутгийнхаа байгаль орчны үнэ цэнийг хадгалан хамгаалж, байгалийн баялгийг урт хугацаанд хариуцлагатай ашиглахыг зорьдог. Бид энэхүү үүрэг амлалтыг санал нэгтгэйгээр хэрэгжүүлэхээ дараах байдлаар нотлон харуулсан нийлүүлэгчидтэй хамтран ажилладаг.

- Үйл ажиллагаа явуулж байгаа бүс нутгийнхаа байгаль орчны үнэ цэнийг ойлгодог, байгаль орчныг хамгаалах арга хэмжээ авдаг.
- Хэрэглээг багасгах, дахин ашиглах, дахин боловсруулах замаар байгаль орчны болон баялгийн менежментээ тасралтгүй сайжруулдаг.
- Байгаль орчны мэдээллийг холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу цуглуулж, боловсруулж, тайлагнадаг.
- Үйлдвэрлэсэн эсвэл үйлдвэрлэхээр гэрээ байгуулсан бүтээгдэхүүн нь дайн байлдааныг санхүүжүүлэх ашигт малтмал агуулаагүй байх.

5. Гамшгийн бэлэн байдал, бизнесийн үйл ажиллагааг сэргээх төлөвлөгөө

Бид байгалийн үзэгдэл, гамшиг, цар тахал зэрэг урьдчилан таамаглах боломжгүй үйл явдлын үед ажилчид, үйл ажиллагаа, хангамжийн сүлжээнийхээ аюулгүй байдлыг хангах гамшгийн бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөө бүхий нийлүүлэгчидтэй хамтран ажилладаг.

6. Орон нутгийн ард иргэд

Бид орон нутгийн болон бүс нутгийн ард иргэдтэй бие биенээ хүндлэх, харилцан суралцах, харилцан ашигтай байх зарчим дээр суурилсан бат бөх, тууштай харилцаа тогтоодог. Бид орон нутгийн нийгэм, эдийн засаг, институцийн хөгжлийг дэмждэг нийлүүлэгчидтэй хамтран ажилладаг.

- Үйл ажиллагаа явуулж байгаа орон нутгаас ажиллах хүч, бараа үйлчилгээ авах, чадавхжуулахад чиглэсэн олон нийтийн оролцоо, санаачлагыг дэмждэг.
- Үйл ажиллагаа явуулахдаа ХДХВ/ДОХ, сүрьеэ, хумхаа гэх мэтийн өвчнөөс урьдчилан сэргийлэх хөтөлбөрүүдэд хамрагддаг.

7. Мэдээлэл, тайлан

Бид шударга, нээлттэй харилцаж итгэлцлийг бий болгодог. Бид холбогдох мэдээллийг цаг тухайд нь, үнэн зөв гаргаж өгдөг нийлүүлэгчидтэй хамтран ажилладаг.

- Холбогдох хууль эрх зүйн болон зохицуулалтын шаардлагууд, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зарчмуудын дагуу санхүүгийн тайлан, бизнесийн бүртгэлээ үнэн зөвөөр хөтөлдөг.
- Зохицуулалтын ба гэрээний шаардлагын дагуу эдийн засаг, нийгэм, байгаль орчны гүйцэтгэлээ тайлагнадаг.
- Бусад талуудын (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх, нууц мэдээлэл гэх мэт) оюуны өмчийн эрхийг хангадаг.

8. Менежментийн үүрэг амлалт

Рио Тинто компанитай хамтран ажиллаж буй нийлүүлэгч нар Нийлүүлэгчдийн ёс зүйн дүрэмд заасан зарчмуудыг хүлээн зөвшөөрч, түүнд заасан үүрэг амлалтуудыг авч хэрэгжүүлж, түгээн дэлгэрүүлдэг. Энэ нь туслан гүйцэтгэгч нарт мөн хамаарна.

Бид ил тод байх соёлыг эрхэмлэж, үндсэн болон гэрээт ажилчид, нийлүүлэгчид, бусад оролцогч талуудыг өөрт тулгарсан хүндрэл бэрхшээл, санаа зовоосон асуудлаа ил тод илэрхийлэхийг дэмждэг. Рио Тинто группийн нийлүүлэгчид болон тэдний ажилчид myVoice буюу Рио Тинто группийн олон хэл дээр санал хүсэлт хүлээн авдаг, бие даасан, нууцлалыг хангасан, шүгэл үлээх үйлчилгээг ашиглах боломжтой. myVoice нь аливаа санаа зовоосон асуудал, зохисгүй үйлдлийг хараат бусаар, нэрээ нууцлан бидэнд шууд мэдээлэх аюулгүй арга юм.

Тус аргыг ашиглан санааг тань зовоож буй ажил хэрэг, хувь хүний зан төлөвтэй холбоотой асуудлыг мэдээлж болно. Үүнд Рио Тинто группийн бодлого, журмын зөрчил, хүний эрх, аюулгүй ажиллагаа, байгаль орчин, санхүүгийн тайлагнал, залилан, бизнесийн ёс зүйн асуудлууд орно.

Хүлээн авсан бүх мэдээллийн нууцлалыг чандлан хадгалдаг. Нийлүүлэгчдийн ёс зүйн дүрэм, эсвэл Рио Тинто группийн Бидний ажлын арга барилд харшилсан аливаа үйлдэл, нөхцөл байдлын талаар олж мэдсэн бол Рио Тинто группийн ажилтанд шууд мэдэгдэх, эсвэл myVoice платформыг ашиглан мэдээлэхийг бид нийлүүлэгчдэдээ уриалдаг. Таны санааж зовоож буй аливаа асуудлыг тоолгүй өнгөрөөх бус, myvoice@riotinto.com хаягаар бидэнд заавал мэдээлээрэй.

Рио Тинто ПЛС
Их Британи,
Лондон хот SW1Y 4AD,
Гэгээн Жеймсийн талбай 6,
Утас: +44 (0)20 7781 2000

Рио Тинто Лимитед
Австрали улс,
Мельбурн хот,
Викториа 3000,
Коллинс гудамж 120,
Утас: +61 (0) 3 9283 3333